



ДИЖИТАЛ ЭКСЧЕЙНЖ МОНГОЛИА

ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА

ГАРЧИГ

A.ТАНИЛЦУУЛГА	3
1.TRADE.MN	4
1.1 Компанийн тухай	4
1.2 Trade.mn криптовалютын биржийн онцлог, давуутал	4
2.TRD COIN	4
2.1 DIGITAL EXCHANGE COIN	4
B.БҮРТГЭЛ ҮҮСГЭХ ЗААВАР	6
1. Хувь хэрэглэгчийн бүртгэл үүсгэх	6
C.НЭВТРЭХ ЗААВАР	12
1. 2FA ашиглаж нэвтрэх	13
2. 2FA ашиглахгүй нэвтрэх	15
D.ХЭТЭВЧ АШИГЛАХ ЗААВАР	17
1. Орлого хийх заавар	18
1.1 Төгрөгийн орлого хийх	18
1.2 Крипто орлого хийх	23
2. Зарлага хийх заавар	25
2.1 Төгрөгийн зарлага хийх	25
2.2 Крипто зарлага хийх	28
3. Тайлан үзэх заавар	32
3.1 Орлого/Зарлагын түүх харах	32
3.2 Гүйлгээний түүх харах	33
E.АРИЛЖАА ХИЙХ ЗААВАР	34
1. Захиалга өгөх заавар	35
1.1 Нөхцөлт арилжааны захиалга өгөх	35
1.2 Зах зээл арилжааны захиалга өгөх	37
2. Захиалга цуцлах	39
3. Арилжаа болон захиалгын түүх шалгах	40
F.ХЭРЭГЛЭГЧИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЛИЙН ЦЭС АШИГЛАХ	42
1. Ерөнхий мэдээллээ харах	43
2. Найзаа урих	45
3. Google Authenticator идэвхжүүлэх	46
4. Google Authenticator цуцлах	50
5. Имэйлээр Google Authenticator цуцлах хүсэлт илгээх	51
G.SAVINGS ҮЙЛЧИЛГЭЭ АШИГЛАХ	52
H.ТУСЛАМЖ ЦЭС АШИГЛАХ	55
1. Түгээмэл асуултууд	56
2. Хэрэглэгчийн хүсэлт илгээх	57
3. Утасны апп татах	59
I.ТОХИРГОО	60
1. Нэвтрэх нууц үгээ солих	61
2. Гар утасны дугаараа солих	63
3. Имэйл хаяг	63
4. Шинээр хаяг хадгалах	64



ДИЖИТАЛ ЭКСЧЕЙНЖ МОНГОЛИА

А.ТАНИЛЦУУЛГА

А.ТАНИЛЦУУЛГА

1. TRADE.MN

1.1 КОМПАНИЙН ТУХАЙ

Дижитал Эксчейнж Монголиа ХХК нь Монгол улсын анхны криптовалютын бирж болох www.trade.mn онлайн платформыг үүсгэн байгуулж 2017 оны 10-р сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Энэхүү платформ нэвтэрснээр Монголчууд бид дэлхийн хөгжингүй улсуудтай мөр зэрэгцэн, олон улсын 400 гаруй криптовалютын биржид арилжаалагдаж буй криптовалютуудын арилжаанд эх орондоо, хурдан шуурхай, хялбар оролцох боломжтой болсон билээ.

Манай хэрэглэгчид өдөр бүр, тасралтгүй нэмэгдэж 230 гаруй мянгад хүрээд байгаа бөгөөд дэлхийн бусад тэргүүлэгч биржүүдтэй адил 7/24/365 хоногийн туршид тасралтгүй ажиллаж байна. Арилжааны самбарт MHT суурьтай 30 хослол, TRD суурьтай 10 хослол, MONT суурьтай 11 хослол, USDT суурьтай 12 хослол нийт криптовалютын 63 хослол арилжаалагддаг. Харилцагч, хэрэглэгчид маань веб платформ, мобайл аппликэйшн, криптовалютын АТМ ашиглан арилжаанд оролцдог.

1.2 TRADE.MN КРИПТОВАЛЮТЫН БИРЖИЙН ОНЦЛОГ, ДАВУУ ТАЛ

Trade.mn арилжааны платформ нь криптовалютын арилжаанд оролцох сонирхолтой хувь хүн, байгууллага бүртгэл хийлгэхээс эхлэн зарлага хийх хүртэлх бүхий л үйлдлийг хялбаршуулж, автоматжуулсан бүрэн онлайн, Дижитал бирж юм.

Trade.mn бирж нь дараах онцлог, давуу талуудтай

- » Монгол улсын анхны бүрэн цахимжсан, дижитал бирж
- » Олон улсын шилдэг нууцлал, хамгаалалт бүхий криптовалютын өөрийн wallet, олон улсад бүртгэлтэй full node service-үүдтэй
- » Хамгийн олон блокчэйн сүлжээний бүртгэлтэй
- » Хамгийн удаан аюулгүй, найдвартай, тасралтгүй ажилласан арилжааны систем, wallet, блокчэйн бүртгэлийн систем
- » Олон улсын TIER II дата төвд байршдаг
- » ISO27001:2013 олон улсын стандартыг амжилттай нэвтрүүлж, баталгаажсан
- » Оюуны өмчөөр хамгаалагдсан
- » 24/7/365 цагийн тасралтгүй ажиллагаа
- » Монголын анхны криптовалютын АТМ
- » Хамгийн олон харилцагч, хэрэглэгчидтэй

2. TRD COIN

2.1 DIGITAL EXCHANGE COIN

Койны нэр	Digital Exchange Mongolia
Койны тиккер	TRD
Койны хаяг	0xfc49167b119d0cdccfbfccc919628e7eacdfddd8
Койн гаргагч	Дижитал Эксчейнж Монголиа ХХК
Койны стандарт	BEP20
Нийт гаргасан тоо хэмжээ	20,000,000,000
Бүртгэл	Trade.mn криптовалютын бирж



ДИЖИТАЛ ЭКСЧЕЙНЖ МОНГОЛИА


В.БҮРТГЭЛ ҮҮСГЭХ ЗААВАР

В.БҮРТГЭЛ ҮҮСГЭХ ЗААВАР


Хэрэглэгч TRADE.MN платформд хандан Бүртгүүлэх товчлуур дээр даран шинээр бүртгэл үүсгэх боломжтой. Манай системд **Хувь хүн** болон **Байгууллагын бүртгэл** үүсгэж болох бөгөөд та өөрт тохирох бүртгэлийн хэлбэрийг сонгон бүртгэлээ үүсгэнэ.

1. Хувь хэрэглэгчийн бүртгэл үүсгэх

▶ **АЛХАМ 1.** Шинээр бүртгэл үүсгэхээр Trade.mn платформд хандаж Бүртгүүлэх цэсийг сонгоно.



▶ **АЛХАМ 2.** Хувь хүний бүртгэл үүсгэх товчин дээр дарна.




▶ **АЛХАМ 3.** Та өмнө нь бүртгэл үүсгэж байгаагүй Имэйл болон РД-аа оруулж бүртгэл үүсгэнэ.

1. Нууц үгээ зааврын дагуу оруулна уу.
2. Үйлчилгээний нөхцлийг уншиж танилцан цааш үргэлжлүүлнэ үү.
3. “Би робот биш” хэсгийг чагтлахаа мартуузай.
4. Дээрх мэдээллийг үнэн зөв бөглөж дуусгаад **Бүртгүүлэх** товчийг дарна.




Анхааруулга: Таны зохиож буй нууц үг хамгийн багадаа 6 оронтой 1 том үсэг, 1 жижиг үсэг, 1 тоо, 1 тусгай тэмдэгт орсон байх ёстой.

► **АЛХАМ 4.** Таны бүртгүүлсэн имэйл хаяг руу имэйл баталгаажуулах код илгээгдэнэ.



► **АЛХАМ 5.** Та бүртгүүлсэн имэйл хаягаа шалгаж имэйлээр ирсэн 6 оронтой кодыг баталгаажуулах код хийх хэсэгт оруулан **Баталгаажуулах** товч дээр дарна.



Анхааруулга: Inbox-д имэйл ирээгүй байвал Spam болон Junk имэйлээ давхар шалгаарай.

➤ **АЛХАМ 6.** Баталгаажуулалт хийсний дараа Утасны дугаар хэсэгт дугаараа оруулж **Баталгаажуулах** товч дээр дарна.

1 Утасны дугаар

2 ДАН холбох

3 Банкны данс

Утасны дугаар баталгаажуулах

УТАСНЫ ДУГААР

Анхааруулга

- Монголд амьдарч буй дотоодын иргэдийн хувьд гар утасны дугаараа баталгаажуулах шаардлагатай ба "Баталгаажуулах" товч дээр дарж та гар утасны дугаараа баталгаажуулна уу.
- Гүйлгээ хийх үед таны утсанд баталгаажуулах код илгээгдэх тул та өөрийн одоо ашиглаж буй дугаараа оруулна уу.

Баталгаажуулах

➤ **АЛХАМ 7.** Утасны дугаараа баталгаажуулахын тулд мессэжээр ирсэн кодыг 'Код оруулна уу' хэсэгт оруулж **"Би робот биш"**-г чагталж **Баталгаажуулах** товч дээр дарж баталгаажуулна.

1 Утасны дугаар

2 ДАН холбох

3 Банкны данс

Баталгаажуулалт

УТАСНЫ ДУГААР

Баталгаажуулах код

Код авах товч дээр дарж [redacted] дугаар луу илгээгдсэн баталгаажуулах кодыг доод хэсэгт оруулна уу!

123456 Илгээсэн (102сек)

I'm not a robot reCAPTCHA Privacy - Terms

Баталгаажуулах

➤ **АЛХАМ 8.** Дан баталгаажуулалт хийхдээ **'Дан холбох'** гэсэн товчин дээр дарна.

1 Утасны дугаар

2 ДАН холбох

3 Банкны данс


Дан баталгаажуулах

Анхааруулга


- ДАН танилт нэвтрэлтийн системээр эрхээ баталгаажуулна уу?

Дан холбох

➤ **АЛХАМ 9. E-Mongolia дээрх өөрийн бүртгэл рүү нэвтэрч орно.**



➤ **АЛХАМ 10. Мэдээлэл авах хүсэлтэнд зөвшөөрч 'Зөвшөөрөх' товчин дээр дарна.**



▶ АЛХАМ 11. Шинэ данс нэмэх

1. Арилжааны банк хэсэгт Хаан, Голомт, ХХБ, Төрийн банкнаас сонгоно.
2. Валют хэсгээс MNT сонголтыг хийнэ.
3. Дансны дугаар хэсэгт өөрийн нэр дээрх дансаа оруулна.
4. Анхааруулга хэсэгтэй сайтар танилцаж **Данс баталгаажуулах** товч дээр дарна.

Шинэ данс нэмэх

АРИЛЖААНЫ БАНК ВАЛЮТ

1 2

ДАНСНЫ ДУГААР

3

4

- Анхааруулга
 - Зөвхөн өөрийн нэр дээрх дансыг бүртгэнэ үү!
 - Таны нэмсэн данс руу "Баталгаажуулах КОД" бүхий гүйлгээ хийгдэх бөгөөд 6 оронтой кодыг оруулснаар таны данс баталгаажих болно.

[Данс баталгаажуулах](#)

▶ АЛХАМ 12. 24 цагийн дотор таны холбосон дансанд баталгаажуулах код бүхий 1 төгрөгний гүйлгээ хийгдэх бөгөөд уг гүйлгээний утга дээр данс баталгаажуулах 6 орон бүхий код байна. Үүний дараа та **“Баталгаажуулах шаардлагатай”** товчин дээр дарна.

- ✓ Утасны дугаар
- ✓ ДАН холбох
- 3 Банкны данс

Бүртгэлтэй данс

Валют	Банкны нэр	Банкны данс	Төлөв	Үйлдэл
MNT	Голомт банк	3105152676	Баталгаажуулах шаардлагатай	

Шинэ данс нэмэх

АРИЛЖААНЫ БАНК ВАЛЮТ

ДАНСНЫ ДУГААР

► **АЛХАМ 13.** Код оруулах хэсэг гарч ирэх бөгөөд код хийх хэсэгт данс баталгаажуулах кодоо оруулж, **“Би робот биш”** хэсгийг чагтлаж **Баталгаажуулах** товчин дээр дарж дансаа баталгаажуулна.

Данс баталгаажсанаар бүртгэл бүрэн хийгдэж дуусах бөгөөд үүний дараа Арилжаанд оролцох, мөн хэтэвч ашиглан Орлого, Зарлага хийх боломжтой болно.

Баталгаажуулалт

Нүүр > Баталгаажуулалт

Данс баталгаажуулах

ДАНСНЫ ДУГААР

Баталгаажуулах код

Банкин дахь таны [redacted] тоот дансанд 1₮-ийн гүйлгээ хийгдсэн ба гүйлгээний утга дээрх кодыг доод хэсэгт оруулна уу.

683403

I'm not a robot reCAPTCHA Privacy - Terms

Баталгаажуулах

Утасны дугаар

ДАН холбох

3 Банкны данс

Төлөв

Үйлдэл

Баталгаажуулах

ВАЛЮТ

Сонгоно уу

Сонгоно уу

ТАНЫ АРИЛЖААНД АМЖИЛТ ХҮСЬЕ! ❤️



ДИЖИТАЛ ЭКСЧЕЙНЖ МОНГОЛИА


С.НЭВТРЭХ ЗААВАР

С.НЭВТРЭХ ЗААВАР

Хэрэглэгч нэвтрэхдээ өөрийн бүртгэлтэй имэйл хаяг болон нууц үгийг ашиглан нэвтрэнэ. Мөн имэйл, нууц үгээс гадна 2FA хамгаалалтыг шаардлагатай тохиолдолд давхар оруулж нэвтрэнэ. 2FA хамгаалалт нь таны хувийн мэдээллийг илүү аюулгүй болгодог тул 2FA хамгаалалтаа идэвхжүүлэхийг зөвлөө.


1. 2FA ашиглаж нэвтрэх

▶ **АЛХАМ 1.** Trade.mn вэбээр хандаж **Нэвтрэх** цэсийг сонгоно.




▶ **АЛХАМ 2.**

1. **Имэйл** хэсэгт өөрийн бүртгэлтэй имэйл хаягийг бичнэ.
2. **Нууц үг** хэсэгт өөрийн зохиосон манайд нэвтрэхдээ ашигладаг нууц үгээ хийнэ.
3. **Би робот биш /I'm not a robot/** гэсэн хэсгийг чагталж гарч ирэх даалгаварыг зааврын дагуу хийж нэвтрэнэ.



▶ АЛХАМ 3. Google Authenticator:


- » 2FA код хэсэгт **Google Authenticator** апп дээрх Trade.mn холболтын 6 оронтой кодыг хийж нэвтэрнэ.



Анхааруулга: Google Authenticator апп дээрх 6 оронтой код нь 30 секунд тутамд шинэчлэгдэж байдаг тул та хугацаанд нь амжиж хийгээрэй. Мөн таны утасны цагийн тохиргоо автомат тохиргоо дээр байгаа эсэхийг нь давхар шалгаарай.


▶ АЛХАМ 4. Шинэ төхөөрөмжөөс 2FA хамгаалалттай нэвтрэх:

1. Таны бүртгэлтэй утсанд төхөөрөмж **баталгаажуулах 6 оронтой код мессежээр ирэх** бөгөөд уг кодыг код оруулах хэсэгт хийнэ.
2. 2FA код оруулна уу хэсэгт **Google Authenticator** апп дээрх Trade.mn холболтын 6 оронтой кодыг хийнэ.
3. **I'm not a robot** хэсгийг чагтлана.
4. **Баталгаажуулах** товч дээр дарж нэвтэрнэ.




2. 2FA ашиглахгүй нэвтрэх

▶ **АЛХАМ 1.** Trade.mn вэбээр хандаж **Нэвтрэх** цэсийг сонгоно.




▶ **АЛХАМ 2.**

1. **Имэйл** хэсэгт өөрийн бүртгэлтэй имэйл хаягийг бичнэ.
2. **Нууц үг** хэсэгт өөрийн зохиосон манайд нэвтрэхдээ ашигладаг нууц үгээ хийнэ.
3. **Би робот биш /I'm not a robot/** гэсэн хэсгийг чагталж гарч ирэх даалгаварыг зааврын дагуу хийж нэвтэрнэ.



▶ **АЛХАМ 3.** Шинэ төхөөрөмжөөс 2FA хамгаалалтгүй нэвтрэх:

1. Таны бүртгэлтэй утсанд төхөөрөмж баталгаажуулах 6 оронтой код мессежээр ирэх бөгөөд уг кодыг код оруулах хэсэгт хийнэ.
2. I'm not a robot хэсгийг чагтлана.
3. Баталгаажуулах товч дээр дарж нэвтрэнэ.





ДИЖИТАЛ ЭКСЧЕЙНЖ МОНГОЛИА

Д.ХЭТЭВЧ АШИГЛАХ ЗААВАР


D.ХЭТЭВЧ АШИГЛАХ ЗААВАР

Trade.mn системд бүртгэлээ бүрэн баталгаажуулснаар хэрэглэгчид хэтэвч үүснэ. Уг хэтэвчийг ашиглан криптовалютын болон төгрөгийн орлого, зарлага хүлээн авах боломжтой болно.


1. ОРЛОГО ХИЙХ ЗААВАР

1.1 ТӨГРӨГИЙН ОРЛОГО ХИЙХ

▶ **АЛХАМ 1.** Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр **нэвтэрч** орно.



▶ **АЛХАМ 2.** Баруун дээд буланд байх **Хэтэвч** гэсэн товчин дээр дарна.



▶ **АЛХАМ 3. Орлого товчин дээр дарна.**

Ерөнхий

Ойролцоо үлдэгдэл
 ***** BTC
 ≈ *****MNT

Үндсэн хөрөнгийн мэдээлэл Бага дүнтэйг нуух

Хослолууд	Захиалгад байгаа	Savings-д байгаа	Үлдэгдэл	Тусгаарласан
MNT Төгрөг	0 0 ₮	0 0 ₮	929 929 ₮	0 0 ₮
TRD Digital Exchange Coin	0 0 ₮	0 0 ₮	1,000 260 ₮	0 0 ₮
ICTG ICTG Security Token	0 0 ₮	0 0 ₮	0 0 ₮	0 0 ₮

▶ **АЛХАМ 4. Төгрөг /MNT/ сонголтыг сонгоно.**

1 Койн сонгох
 2 Хаяг

Орлогын сонголтоо хийнэ үү Орлого/Зарлага түүх


Хайлт хийх...

#	Нэр
1	Төгрөг MNT
2	Digital Exchange Coin TRD
3	ICTG Security Token ICTG
4	Storepay Coin SPC
5	BIDCoin BID


QPay болон Банкны дансаар төгрөгийн орлого хийх боломжтой байдаг тул QPay болон Банкны данс сонголтоос хамаарч орлого хийх үйлдлүүд нь өөр байдаг.

Qpay:


▶ **АЛХАМ 5.** Qpay сонголтыг сонгосон бол орлого хийх мөнгөн дүнгээ бичээд Qpay орлого хийх гэсэн товчин дээр дарна.



▶ **АЛХАМ 6.** Та **1 дугаарт** Орлого хийх мөнгөн дүнг бичих эсвэл **2 дугаарт** орлого хийх мөнгөн дүнгээ сонгоно уу.




▶ **АЛХАМ 7.** Гарч ирсэн QR кодыг өөрийн бүртгэлтэй банкны интернэт банк дээрх QR уншигчаар уншуулж орлогын гүйлгээг хийнэ.




Банкны дансаар:


▶ АЛХАМ 8. Банкны данс гэсэн сонголтыг сонгоно.



▶ АЛХАМ 9. Өөрийн бүртгэлтэй дансны харилцах банкыг сонгоно.



▶ **АЛХАМ 10.** Дансны дугаар, Дансны нэр, Гүйлгээний утгыг хуулж авна.



▶ **АЛХАМ 11.** Өөрийн бүртгэлтэй банкны интернэт банкаар нэвтэрч гүйлгээ хийнэ.


Хэрэглэгч зааврын дагуу орлогын гүйлгээ шилжүүлснээр 10 минутын дотор хэтэвч автоматаар цэнэглэгдэх болно. Төгрөгийн орлого хийхдээ дараах зүйлсийг анхаарна уу.



- » Гүйлгээний утга дээр бүртгэлтэй имэйл хаягаа бичиж шилжүүлнэ.
- » Гүйлгээний утга алдаатай шилжүүлсэн тохиолдолд гүйлгээг буцаана.
- » Банк хооронд шилжүүлэг хийсэн тохиолдолд банкны цагийн хуваариар хэтэвч цэнэглэгдэх тул банк хоорондын шилжүүлэг хийхдээ анхаарна уу.
- » Зөвхөн орлого хүлээн авах данс руу шилжүүлэг хийх бөгөөд хэрэв тэгээгүй тохиолдолд орлого автоматаар орохгүй болно.
- » Зөвхөн trade.mn-д бүртгүүлж, баталгаажуулсан банкны данснаасаа орлогыг шилжүүлэх шаардлагатай ба орлого 10 минутын дотор орно.
- » 23:30-00:30 цагийн хооронд банкны өндөрлөгөө хаалт таардаг тул тухайн хугацаанд орлого хийхгүй байхыг анхаарна уу.

1.2 КРИПТО ОРЛОГО ХИЙХ

▶ **АЛХАМ 1.** Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр **НЭВТЭРЧ** орно.



Нэвтрэх

Та доорх URL-р вэб хөтөчөөс орж байгааг сайтар шалгана уу!

<https://trade.mn>

ИМЭЙЛ


НУУЦ УГ

Нууц үг мартсан?

I'm not a robot reCAPTCHA Privacy · Terms

Нэвтрэх

▶ **АЛХАМ 2.** Баруун дээд буланд байх **ХЭТЭВЧ** гэсэн товчин дээр дарна.




trade АРИЛЖАА ТУСЛАМЖ SAVINGS NFT ШИНЭ

ХЭТЭВЧ


Крипто арилжааг минутын дотор...

Bitcoin, Ethereum, BNB гэх мэт дэлхийн томоохон криптог худалдан авах боломжтой.

▶ АЛХАМ 3. Орлого товчин дээр дарна.




▶ АЛХАМ 4. Орлого хийх гэж буй койноо сонгоно.



▶ АЛХАМ 5.

1. Сүлжээ сонгох хэсэгт өөрийн орлого хийх гэж байгаа койны сүлжээг сонгоно.
2. Сүлжээг сонгосон бол таны койн орлогын хаяг гарч ирэх тул хаягаа хуулж авна.



▶ **АЛХАМ 6.** Шилжүүлэгч талын Зарлага хүлээн авах хаяг хэсэгт манай дээрх өөрийн койн орлогын хаягийг хуулж тавиад сүлжээний сонголтоо зөв сонгон зарлага гаргана.



Анхааруулга: Хэрэглэгч зааврын дагуу орлогын гүйлгээ шилжүүлснээр манай дээр заасан сүлжээний баталгаажуулалтын тоонд хүрсэн тохиолдолд хэтэвч автоматаар цэнэглэгдэх болно. Крипто орлого хийхдээ дараах зүйлсийг анхаарна уу.

- » Буруу сүлжээгээр эсвэл хаягаа буруу шилжүүлсэн гүйлгээг TRADE.MN хариуцахгүй.
- » Contract орлогын шилжүүлэг дэмжихгүй.
- » Манай дээр бүртгэлгүй койны шилжүүлэг хүлээн авахгүй.
- » Сүлжээний сонголтоо зөв хийсэн эсэхээ шалгана уу.


2. ЗАРЛАГА ХИЙХ ЗААВАР

2.1 ТӨГРӨГИЙН ЗАРЛАГА ХИЙХ


▶ **АЛХАМ 1.** Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр **нэвтэрч** орно.

▶ **АЛХАМ 2.** Баруун дээд буланд байх **Хэтэвч** гэсэн товчин дээр дарна.

▶ **АЛХАМ 3. Зарлага товчин дээр дарна.**




▶ **АЛХАМ 4. Төгрөг /MNT/ сонголтыг сонгоно.**




▶ **АЛХАМ 5.**

1. Дансаа сонгоно уу хэсэгт өөрийн бүртгэлтэй банкны дансыг сонгоно.
2. Зарлага хийх хэмжээ хэсэгт зарлага гаргах хүсэлтэй байгаа хэмжээгээ оруулна.
3. Зарлага гаргах товчин дээр дарна.




▶ **АЛХАМ 6.** Таны зарлагын мэдээллийн хуудас гарч ирэх бөгөөд уг хэсэгтэй сайн танилцаж **За ойлголоо, Үргэлжлүүлье** товчин дээр дарна.



▶ **АЛХАМ 7.** Зарлага баталгаажуулалтын хэсэгт шилжинэ.

1. **Баталгаажуулах код** хэсэгт таны бүртгэлтэй утсанд ирсэн зарлага баталгаажуулах 6 оронтой кодыг хийнэ.
2. **2FA код** хэсэгт Google Authenticator апп дээрх 6 оронтой кодыг хийнэ.
3. **Баталгаажуулах** товчин дээр дарж зарлагыг баталгаажуулна.




Анхааруулга: Хэрэглэгч зааврын дагуу зарлагын баталгаажуулалт хийснээр зарлага дарааллын дагуу гарах болно. Төгрөгийн зарлага хийхдээ дараах зүйлсийг анхаарна уу.


- » 2FA хамгаалалтыг идэвхжүүлсэн байх шаардлагатай.
- » Зарлага гаргах данс нь хэрэглэгчийн өөрийн нэр дээрх данс байх шаардлагатай.

2.2 КРИПТО ЗАРЛАГА ХИЙХ


➤ **АЛХАМ 1.** Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр **нэвтэрч** орно.




➤ **АЛХАМ 2.** Баруун дээд буланд байх **Хэтэвч** гэсэн товчин дээр дарна.



➤ **АЛХАМ 3.** Зарлага товчин дээр дарна.



➤ **АЛХАМ 4.** Зарлага хийх койныг сонгоно.



▶ АЛХАМ 5.

1. Сүлжээ сонгох хэсэгт тухайн зарлага хийх гэж байгаа койны сүлжээг сонгоно.
2. Зарлага хийх хаяг хэсэгт Орлого хүлээн авах талын хаягийг хуулж тавина.
3. Зарлага хийх хэмжээ хэсэгт зарлага гаргах хүсэлтэй хэмжээгээ оруулна.
4. Хүлээн авагчийн Овог, Нэр хэсэгт хүлээн авагчийн овог нэрийг бичнэ.
5. Хүлээн авагчийн хаягийн төрөл хэсгээс Бирж хаяг, Хэтэвч хаяг гэсэн сонголтоос таарах сонголтыг сонгож Хэтэвч сонгох хэсгээс биржийн нэр эсвэл хэтэвчийг үнэн зөв сонгоно.
6. Шилжүүлэг хийх хөрөнгийн эх үүсвэр хэсгээс өөрийн эх үүсвэрийн аль тохирох үнэн зөв сонголтыг сонгоно.
7. Зарлага гаргах товчин дээр дарна.

Зарлагын сонголт

Койн Нийт үлдэгдэл: 5,123.14906086 TRD

Койн: TRD

Сүлжээ сонгох

1 BINANCE SMART CHAIN [BEP20]

Анхааруулга
[Зөвхөн BEP20 сүлжээний хаяг оруулна]

ЗАРЛАГА ХИЙХ ХАЯГ

Шинэ хаяг | Хадгалсан хаягууд

ЗАРЛАГА ХИЙХ ХАЯГ

2 0xD912d3F0233e29cBb699674862d8661fA9114a66

ЗАРЛАГА ХИЙХ ХЭМЖЭЭ Боломжит үлдэгдэл: ██████████

3 5,000 MAX

Зарлагын доод хэмжээ: 2,000 TRD
Зарлагын дээд хэмжээ: 250,000,000 TRD

ХҮЛЭЭН АВАГЧИЙН ОВОГ, НЭР

4 ██████████

Хүлээн авагчийн хаягийн төрөл

5 Trade


Шилжүүлэг хийх хөрөнгийн эх үүсвэр

6 Хувьцаа, үнэт цаас, крип...


Шийтгэл 500 TRD | Таны авах дүн 4,500 TRD

7 Зарлага гаргах

▶ **АЛХАМ 6.** Гарч ирэх анхааруулга хэсэгтэй танилцаж **Тийм, Зөвшөөрнө** товчин дээр дарна.




▶ **АЛХАМ 7.** Таны зарлагын мэдээллийн хуудас гарч ирэх бөгөөд уг хэсэгтэй сайн танилцаж **За ойлголоо, Үргэлжлүүлье** товчин дээр дарна.



Анхааруулга: Шилжүүлэг хийж буй койны зарлагын сүлжээ хүлээн авагч талын орлогын сүлжээтэй таарч буй эсэхийг сайн шалгана.

▶ **АЛХАМ 8.** Зарлага баталгаажуулалтын хэсэгт шилжинэ.

1. **Баталгаажуулах код** хэсэгт таны бүртгэлтэй утсанд ирсэн зарлага баталгаажуулах 6 оронтой кодыг хийнэ.
2. **2FA код** хэсэгт Google Authenticator апп дээрх 6 оронтой кодыг хийнэ.
3. **Баталгаажуулах** товчин дээр дарж зарлага гарна.
 - » Зарлага хийх хаяг нь хүлээн авагч талын хаягтай таарч буй эсэхийг сайтар нягтлаж зарлага баталгаажуулалтаа хийнэ үү.



Анхааруулга: Хэрэглэгч зааврын дагуу зарлагын баталгаажуулалт хийснээр зарлага дарааллын дагуу гарах болно.

Крипто зарлага хийхдээ дараах зүйлсийг анхаарна уу.


- » Буруу сүлжээгээр эсвэл хаягаа буруу шилжүүлсэн гүйлгээг TRADE.MN хариуцахгүй.
- » Сүлжээний сонголтоо зөв хийсэн эсэхээ шалгана.
- » Хаягаа зөв хуулж тавьсан эсэхээ сайтар шалгана.
- » 2FA хамгаалалтыг идэвхжүүлсэн байх шаардлагатай.
- » Зарлага хийх хаягаа дахин нягталж харахыг зөвлөө.

3. ТАЙЛАН ҮЗЭХ ЗААВАР

Тайлан хэсгээс хэрэглэгч Орлого/Зарлага, Гүйлгээний түүх зэрэг түүхээ хугацаагаар шүүж хайж харах боломжтой бөгөөд файл хэлбэрээр татаж авах боломжтой байдаг.

3.1 ОРЛОГО/ЗАРЛАГЫН ТҮҮХ ХАРАХ

▶ **АЛХАМ 1.** Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр **нэвтэрч** орно.



Нэвтрэх

Та доорх URL-р вэб хөтөчөөс орж байгааг сайтар шалгана уу!

<https://trade.mn>

ИМЭЙЛ

НУУЦ ҮГ


Нууц үг мартсан?

I'm not a robot

reCAPTCHA Privacy - Terms

Нэвтрэх

▶ **АЛХАМ 2.** Баруун дээд буланд байх **цаасны зурган** дээр дарна.



trade АРИЛЖАА ТУСЛАМЖ SAVINGS NFT ШИНЭ


ХЭТЭВЧ

Крипто арилжааг минутын дотор...

Bitcoin, Ethereum, BNB гэх мэт дэлхийн томоохон криптог худалдан авах боломжтой.


▶ АЛХАМ 3. Орлого/Зарлагын түүх шалгах:

1. **Валют сонгох** хэсэгт шүүж харах гэж байгаа валютаа сонгоно.
2. **Сонгох** хэсэгт Орлого, Зарлагын төрлөө сонгоно.
3. **Хугацаа** хэсэгт хамрах хугацаагаа оруулна.
4. **Хайх** товчийг дарна.
5. Хэрэв файлаар авах хүсэлтэй бол та **Экспорт** товчин дээр дарж файлаар авах боломжтой.



3.2 ГҮЙЛГЭЭНИЙ ТҮҮХ ХАРАХ

1. **Валют сонгох** хэсэгт шүүж харах гэж байгаа валютаа сонгоно.
2. **Хослол сонгох** хэсэгт шүүж харах гэж байгаа хослолоо сонгоно.
3. **Төрөл сонгох** хэсэгт гүйлгээний төрлөө сонгоно.
4. **Хугацаа** хэсэгт хамрах хугацаагаа оруулна.
5. **Хайх** товчийг дарна.
6. Хэрэв файлаар авах хүсэлтэй бол та **Экспорт** товчин дээр дарж файлаар авах боломжтой.





ДИЖИТАЛ ЭКСЧЕЙНЖ МОНГОЛИА


Е.АРИЛЖАА ХИЙХ ЗААВАР

Е.АРИЛЖАА ХИЙХ ЗААВАР

1. ЗАХИАЛГА ӨГӨХ ЗААВАР

1.1 НӨХЦӨЛТ АРИЛЖААНЫ ЗАХИАЛГА ӨГӨХ

➤ АЛХАМ 1. Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр **нэвтэрч** орно.



Нэвтрэх

Та доорх URL-р вэб хөтөнцөс орж байгааг сайтар шалгана уу!

<https://trade.mn>

ИМЭЙЛ

НУУЦУГ


Нууц үг мартсан?

I'm not a robot

РЕКАРТОНА
Privacy - Terms

Нэвтрэх

➤ АЛХАМ 2. Арилжаа цэсийг сонгоно.




trade АРИЛЖАА ТУСЛАМЖ SAVINGS NFT ШИНА ХЭТЭВЧ

Крипто арилжааг минутын дотор...

Bitcoin, Ethereum, BNB гэх мэт дэлхийн томоохон криптог худалдан авах боломжтой.

▶ **АЛХАМ 3.** Хослол дундаас өөрийн арилжаа хийх хослолоо сонгоно.



▶ **АЛХАМ 4.** Авах/Зарах захиалга өгөх хэсгийг ямар захиалга өгөхөөс хамаарч сонгоно.

Нөхцөлт цэсийг сонговол нөхцөлт үнийн захиалга өгнө.

НӨХЦӨЛТ
ЗАХ ЗЭЭЛ

TRD АВАХ

₮ 672.479 MNT

Ханш 1 MNT

Хэмжээ 2 TRD

0%

Нийт 0 MNT

3 TRD Авах

TRD ЗАРАХ

₮ 7,318.783 TRD

Ханш 1 MNT

Хэмжээ 2 TRD

0%

Нийт 0 MNT

3 TRD Зарах

1. Ханш хэсэгт авах/зарахыг хүсэж буй ханшийн үнийг оруулна.
2. Хэмжээ хэсэгт авах/зарахыг хүсэж буй тоо хэмжээгээ оруулна.
3. Авах/Зарах товчийг дарж захиалга өгнө.



- » Ханш болон хэмжээг оруулахад Нийт дүн автомаар бодогдоно.
- » Ханшийн үнийг оруулаад Хэрчим дээрээс нийт дүнгийн хэмжээг сонгосон тохиолдолд хэмжээ нь автоматаар бодогдоно.




Анхааруулга: Trade.mn нь крипто валютын цахим арилжааны бирж тул биржийн арилжааны зарчимаар бүх арилжаа хийгдэнэ. Нөхцөлт буюу дуудлага арилжааны зарчим нь арилжаанд оролцогчдийн хариу үйлдэл дээр тулгуурлан явагдана. Энэ нь идэвхтэй байгаа авах, зарах захиалгуудын ханш хоорондоо таарах үед арилжаа хийгдэнэ гэсэн ойлголт юм. Хэрэв таны оруулсан захиалгын ханш зах зээлийн ханштай таарахгүй бол ханш таарах захиалга орж ирэх хүртэл, эсвэл та өөрөө цуцалтал идэвхтэй хүлээгдсээр байдаг. Хэрэв та койн авах захиалга өгч байгаа бол шимтгэл нь таны захиалга биелсэний дараа тухайн авсан койноос нь бодогдоно. Харин зарах захиалга өгсөн бол таны захиалга биелэх үед төгрөгөөс хасагдаж бодогдоно.

1.2 ЗАХ ЗЭЭЛ АРИЛЖААНЫ ЗАХИАЛГА ӨГӨХ

➤ **АЛХАМ 1.** Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр **нэвтэрч** орно.

➤ **АЛХАМ 2.** Арилжаа цэсийг сонгоно.

▶ **АЛХАМ 3.** Хослол дундаас өөрийн арилжаа хийх хослолоо сонгоно.



▶ **АЛХАМ 4.** Зах зээл захиалга өгөх

Зах зээл захиалга өгвөл зах зээл дээрх хамгийн боломжит дүнгээр захиалга шууд биелэнэ.

НӨХЦӨЛТ **ЗАХ ЗЭЭЛ**

TRD АВАХ 672.479 MNT

Ханш 1 Зах зээл MNT

Дүн 2 MNT

0%

TRD Авах

НӨХЦӨЛТ **ЗАХ ЗЭЭЛ**

TRD ЗАРАХ 7,318.783 TRD

Ханш 1 Зах зээл MNT

Хэмжээ 2 TRD

0%

TRD Зарах

1. Ханш хэсэгт ханш оруулахгүй зах зээл дээрх хамгийн боломжит дүнгээр биелдэг.
2. Дүн хэсэгт хэтэвчний боломжит үлдэгдэлийн хэмжээнд тааруулан дүн оруулна.

1. Ханш хэсэгт ханш оруулахгүй зах зээл дээрх хамгийн боломжит дүнгээр биелдэг.
2. Хэмжээ хэсэгт зарахыг хүсэж буй хэтэвчинд байгаа койны тоо хэмжээнд тааруулан койны хэмжээг оруулна.




Анхааруулга: Trade.mn нь крипто валютын цахим арилжааны бирж тул биржийн арилжааны зарчимаар бүх арилжаа хийгдэнэ. Зах зээлийн зарчим нь захиалгад байгаа хамгий боломжит үнээр арилжаа автоматаар биелэнэ гэсэн ойлголт юм.

Авах тохиолдолд: Зах зээл дээр тогтсон ханшийн хамгийн бага үнээс эхлэн автоматаар биелэнэ.

Зарах тохиолдолд: Зах зээл дээр тогтсон хамгийн өндөр үнээр автоматаар биелэнэ.

2. ЗАХИАЛГА ЦУЦЛАХ

➤ АЛХАМ 1. Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр **нэвтэрч** орно.



Нэвтрэх

Та доорх URL-р вэб хөтөчөөс орж байгааг сайтар шалгана уу!

https://trade.mn

ИМЭЙЛ

НУУЦ УГ


Нууц үг мартсан?

I'm not a robot

reCAPTCHA
Privacy - Terms

Нэвтрэх

➤ АЛХАМ 2. Арилжаа цэсийг сонгоно.



trade

АРИЛЖАА ТУСЛАМЖ SAVINGS NFT ШИНЭ


ХЭТЭВЧ

Крипто арилжааг минутын дотор...

Bitcoin, Ethereum, BNB гэх мэт дэлхийн томоохон криптог худалдан авах боломжтой.

➤ АЛХАМ 3. Идэвхтэй захиалгууд хэсэгт таны оруулсан ханш нь таарч биелээгүй захиалга харагдах болно.


» Өөрийн идэвхтэй захиалгын хойно байх **Цуцлах** гэсэн товчин дээр дарна.



Идэвхтэй захиалгууд Захиалгын түүх Арилжааны түүх

Огноо	Хослол	Авах / Зарах	Ханш	Тоо хэмжээ	Нийт дүн	Билэсэн тоо, хэмжээ	Үйлдэл
2022-08-08 22:14:50	TRD/MNT	САРАХ	1	7,000	7,000	0 0%	Цуцлах


▶ **АЛХАМ 4.** Анхааруулгын самбар дээрх **Тийм** гэсэн товчин дээр дарж цуцална.




Анхааруулга: Хэсэгчлэн биелэж байгаа захиалгыг цуцлах үед шимтгэл нь таны биелсэн хэмжээнд бодогдож, цуцалсан койн/төгрөг нь таны хэтэвчинд буцаж ордог. Цуцалсан захиалгын бичилтээ Захиалгын түүх хэсгээс харах боломжтой.

3. АРИЛЖАА БОЛОН ЗАХИАЛГЫН ТҮҮХ ШАЛГАХ



▶ **АЛХАМ 1.** Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр **нэвтэрч** орно.



➤ АЛХАМ 2. Арилжаа цэсийг сонгоно.




➤ АЛХАМ 3. Захиалгын түүх/Арилжааны түүх гэсэн сонголтыг сонгоно.



➤ АЛХАМ 4. Хослол хэсэгт та тухайн харахыг хүссэн койны хослолыг сонгож харах боломжтой.

➤ АЛХАМ 5. Огноо хэсэгт та хайлтын хугацаагаа оруулах боломжтой.

➤ АЛХАМ 6. Хайх товчин дээр дарж түүхээ хайна.



Анхааруулга: Захиалгын түүх хэсэгт таны Биелсэн захиалга болон Цуцалсан захиалгын түүхүүд харагддаг. Харин Арилжааны түүх хэсэгт зөвхөн таны биелсэн захиалгууд харагдах болно.




ДИЖИТАЛ ЭКСЧЕЙНЖ МОНГОЛИА

Ү.ХЭРЭГЛЭГЧИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЛИЙН ЦЭС АШИГЛАХ


Ү.ХЭРЭГЛЭГЧИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЛИЙН ЦЭС АШИГЛАХ

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЛЭЭ ХАРАХ

➤ АЛХАМ 1. Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр нэвтэрч орно.



➤ АЛХАМ 2. Профайл зурган дээр дараад өөрийн бүртгэлтэй нэрний цэсийг сонгоно.



▶ **АЛХАМ 3. Ерөнхий** хэсэгт Хэрэглэгчийн хувийн мэдээлэл болон Дансны мэдээлэл харагдана. Үүнд:

1. Бүртгэл бүрэн баталгаажсан эсэх
2. Хэтэвчинд байгаа нийт койныг BTC, MNT байдлаар ойролцоох дүнгээр харуулна
3. График үзүүлэлтээр хэтэвчний үлдэгдэл харуулна
4. Хэтэвчинд байгаа койныг койн тус бүрээр харуулна

Ерөнхий Нүүр > Таны бүртгэл

АРИЛЖАА ТУСЛАМЖ SAVINGS NFT **шинэ** ХЭТЭВЧ

Ерөнхий

Нууцлал

Google Authenticator

Дансны удирдлага

Найз урих

Идэвхтэй нэвтрэлтүүд

Хэрэглэгчийн лог

1 **Баталгаажсан**

2 **Хэтэвчний үлдэгдэл**

Хэрэглэгчийн үлдэгдэл ≈ 0.00003972 BTC

Ойролцоо үлдэгдэл $\approx 2,986.92$ MNT

ТАНЫ ХЭТЭВЧИНД

3 **4**

426.86

1,316.65

TRD 5,123.14906086

BNB 0.00036

IHC 0


ECOIN 87.98864707

БОЛОМЖИТ ҮЙЛДЛҮҮД


Орлого Зарлага

2. НАЙЗАА УРИХ


▶ **АЛХАМ 1.** Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр **нэвтэрч** орно.



▶ **АЛХАМ 2.** Профайл зурган дээр дараад **Найзаа урих** цэсийг сонгож Найз урих хуудсыг нээнэ.



► **АЛХАМ 3.** Бүртгэлгүй урих хүний имэйл хаягийг оруулж, **Найз урих** товчийг дарснаар оруулсан имэйл хаягруу урилга илгээгдэх болно.




- » Урьсан хүн тань урилгын линк ашиглан бүртгэлээ бүрэн баталгаажуулснаар урамшууллын койн таны дансанд орох болно.
- » Таны урьсан найз илгээсэн линк дээр дарж бүртгүүлээгүй тохиолдолд танд урамшууллын койн орохгүйг анхаарна уу.


3. GOOGLE AUTHENTICATOR ИДЭВХЖҮҮЛЭХ

2FA/Two Factory Authentication/ буюу Google Authenticator нь хэрэглэгчийг гэрчлэх хоёр шатлалт хамгаалалтын функц бөгөөд таны мэдээллийг илүү аюулгүй болгох давхар хамгаалалтын систем юм.

► **АЛХАМ 1.** Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр **нэвтэрч** орно.



▶ **АЛХАМ 2.** Профайл зурган дээр дараад **2FA нууцлал** цэсийг сонгож 2FA нууцлал хуудсыг нээнэ.



▶ **АЛХАМ 3.** App Store болон Play store-с Google Authenticator апп-ыг татаж суулгана. 2FA хамгаалалтыг идэвхижүүлэхээс өмнө тухайн утасны үйлдлийн системээс хамааран доорх тохиргоог хийнэ.

IOS


1. **Settings**-руу орох
2. **General** цэсийг сонгох



3. **Date & Time** цэсийг сонгох




4. **Set Automatically** тохиргоог идэвхжүүлнэ



ANDROID


1. **Settings**-руу орох
2. **General management** цэсийг сонгох




3. **Date & Time** цэсийг сонгох



4. **Automatic date and time** тохиргоог идэвхжүүлнэ



5. **Google Authenticator** апп-руугаа орох.



- » Settings
- » Time and correction
- » Sync now

▶ **АЛХАМ 4.** QR кодыг Google Authenticator апп-ын Scan a QR code хэсэгт уншуулснаар Trade.mn-д нэвтрэх хамгаалалтын код үүснэ.

» Уг код нь 30 секунд тутамд шинэчлэгдэж байдгийг анхаараарай.

2: QR уншуулах

Өөрийн нууц үг болон Google Authenticator нууц үгийг оруулан "GA Идэвхжүүлэх" товчийг дарна уу!



QR кодыг Google Authenticator апп дээр нэвтрүүлж авна уу!

▶ **АЛХАМ 5.** Код хадгалах хэсэгт харагдаж буй сэргээх кодыг хадгалж авах.

» 32 орон бүхий сэргээх кодыг хадгалж авсанаар 2FA хамгаалалт салсан тохиолдолд сэргээх боломжтой болно. 2FA хамгаалалт салах тохиолдлууд:

- Утсаа алга болгох
- Апп-аа устгах
- Холболтоо устгах гэх мэт.

3: Код хадгалах

Та доорх сэргээх кодыг тэмдэглэж авна уу. Эргэн сэргээх үед хэрэглэгдэнэ.

JM3EOSSNJZDFEV22INBFIVKJKY



▶ АЛХАМ 6. GA Идэвхжүүлэлт.

1. Нууц үг хэсэгт нэвтрэх нууц үгээ хийнэ.
2. GA код хэсэгт Google Authenticator апп дээрх холболт үүссэн 6 оронтой кодыг хийнэ.
3. GA идэвхжүүлэх товчин дээр дарна.

4: GA Идэвхжүүлэх

Өөрийн нууц үг болон Google Authenticator нууц үгийг оруулан "GA Идэвхжүүлэх" товчийг дарна уу!



НУУЦ ҮГ

1

.....



GA КОД

2

123456

GA Идэвхжүүлэх

3



» Хэрэв 2FA хамгаалалт идэвхжүүлэхэд "Хүсэлтийг биелүүлж чадсангүй, Та өөрийн нууц үг болон кодоо дахин шалгана уу" гэсэн алдаа гарвал та өөрийн нэвтрэх нууц үг болон төхөөрөмжийн цагийн тохиргоог дараах зааврын дагуу шалгаж, тохируулна уу.

IOS

1. **Settings**-руу орох
2. **General** цэсийг сонгох
3. **Date & Time** цэсийг сонгох
4. **Set Automatically** тохиргоог идэвхжүүлнэ



General

3. **Date & Time** цэсийг сонгох

Date & Time

4. **Set Automatically** тохиргоог идэвхжүүлнэ

24-Hour Time



Set Automatically



Time Zone

Ulaanbaatar

ANDROID

1. **Settings**-руу орох
2. **General management** цэсийг сонгох
3. **Date & Time** цэсийг сонгох
4. **Automatic date and time** тохиргоог идэвхжүүлнэ
5. **Google Authenticator** апп-руугаа орох



General management

Language and keyboard • Date and time

3. **Date & Time** цэсийг сонгох

Date and time

4. **Automatic date and time** тохиргоог идэвхжүүлнэ

Automatic date and time

Use the date and time provided by your network.



5. **Google Authenticator** апп-руугаа орох


Google Authenticator



- » Settings
- » Time and correction
- » Sync now

4. GOOGLE AUTHENTICATOR ЦУЦЛАХ

▶ АЛХАМ 1. Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр нэвтэрч орно.



Нэвтрэх

Та доорх URL-р вэб хөтөчөөс орж байгааг сайтар шалгана уу!

<https://trade.mn>

ИМЭЙЛ

НУУЦ УГ


Нүүц үг мартсан?

I'm not a robot

reCAPTCHA
Privacy - Terms

Нэвтрэх

▶ АЛХАМ 2. Профайл зурган дээр дараад 2FA нууцлал цэсийг сонгож 2FA нууцлал хуудсыг нээнэ.



trade АРИЛЖАА ТУСЛАМЖ SAVINGS NFT шинэ

ХЭТЭВЧ

Найзаа урих
Найзаа урьж, ураншуулал аваарай

2FA нууцлал
Идэвхтэй

Тохиргоо
Нэмэлт тохиргоо харах

Dark mode
dark/light mode сонгох

Гарах

Крипто арилжааг минутын дотор...

Bitcoin, Ethereum, BNB гэх мэт дэлхийн томоохон криптог худалдан авах боломжтой.

▶ АЛХАМ 3. 2FA тохиргоо идэвхгүй болгох.

1. **Нууц үг** хэсэгт нэвтрэх нууц үгээ хийнэ.
2. **GA код** хэсэгт Google Authenticator апп дээрх холболт үүссэн 6 оронтой кодыг хийнэ.
3. **GA идэвхгүй болгох** товчин дээр дарна.

2FA тохиргоо

Нүүр > Таны бүртгэл

- Ерөнхий
- Нууцлал
- Google Authenticator
- Дансны удирдлага
- Найз урих
- Идэвхтэй нэвтрэлтүүд
- Хэрэглэгчийн лог

GA Идэвхтэй

Хэрэв та GA тохиргоог болиулахыг хүсэж байвал өөрийн нууц үг болон Google Authenticator нууц үгийг оруулан "GA Идэвхгүй болгох" товчийг дарна уу!

GA Хаах

Өөрийн нууц үг болон Google Authenticator нууц үгийг оруулан "GA Идэвхгүй болгох" товчийг дарна уу!

НУУЦ ҮГ
GA КОД

1

2

3



Анхааруулга: 2FA хамгаалалтыг заавал идэвхжүүлсэн байх шаардлагатай байдаг. Хэрэв та 2FA хамгаалалтаа идэвхжүүлээгүй бол зарлага хийх боломжгүй болно.

5. ИМЭЙЛЭЭР GOOGLE AUTHENTICATOR ЦУЦЛАХ ХҮСЭЛТ ИЛГЭЭХ

Өөрийн бүртгэл рүү нэвтрэх чадахгүй байгаа бол өөрийн бүртгэлтэй имэйл хаягаас Support@trade.mn имэйл рүү 2FA хамгаалалтаа цуцлах хүсэлт илгээх боломжтой.

Хүсэлтдээ дараах мэдээллийг хавсарган илгээх шаардлагатай.

- » Иргэний үнэмлэхний нүүр, ар талын зураг
- » Сэргээх код (анх 2FA кодыг идэвхжүүлэх үед сануулсан 32 орон бүхий код)

Хэрвээ сэргээх кодоо тэмдэглэж аваагүй бол доорх мэдээллүүдийг хавсаргасан байх шаардлагатай.

- » Иргэний үнэмлэхний нүүр, ар талын зураг
- » Trade.mn дээрх бүртгэлтэй утасны дугаар
- » Trade.mn дээрх хамгийн сүүлд хийсэн гүйлгээний мэдээлэл
- » Иргэний үнэмлэхээ бариад хажууд нь цаасан дээр Trade.mn, тухайн өдрийн огноо, гарын үсгээ бичээд хамт барьсан селфи зураг



Анхааруулга: Таны илгээсэн хүсэлтийг манайх хүлээн авч 24 цагийн дотор хариу өгөх болно.




ДИЖИТАЛ ЭКСЧЕЙНЖ МОНГОЛИА

G.SAVINGS ҮЙЛЧИЛГЭЭ АШИГЛАХ


G.SAVINGS ҮЙЛЧИЛГЭЭ АШИГЛАХ

Хэрэглэгч та манай биржээс санал болгож буй сонголтуудаас өөрт тохирохыг сонгон үйлчилгээг идэвхжүүлснээр Savings үйлчилгээний хугацаа дуусах хүртэл виртуал хөрөнгөө ашиглах боломжгүй байдлаар өөрийн хэтэвчинд хадгалах юм. Үйлчилгээний хугацаа дуусахад таны хэтэвчинд хадгалсан виртуал хөрөнгө болон үйлчилгээний хугацаанд ноогдох хувь хэмжээгээр урамшуулал нэмэгдэж орно.


➤ **АЛХАМ 1.** Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр **нэвтэрч** орно.



➤ **АЛХАМ 2.** Savings товчин дээр дарж Savings хуудсыг нээнэ.




▶ **АЛХАМ 3.** Өөрийн savings хийхийг хүссэн криптовалюта дээрх **Хадгалах** товчин дээр дарна.



▶ **АЛХАМ 4.** Хэмжээ болон хугацааг сонгож Savings хийнэ.

1. **Хослол сонгоно уу** хэсэгт saving хийхийг хүссэн криптовалютаа сонгоно.
2. **Хэмжээ** хэсэгт savings хийхийг хүсэж байгаа хэмжээгээ оруулна.
3. **Хугацаа** хэсгээс хадгалахыг хүсэж байгаа хугацаагаа сонгоно.
4. **Үйлчилгээний нөхцөлийг** уншиж танилцаад зөвшөөрч байгаа бол зөвлөнө.
5. **Хадгалья** товчин дээр дарна.



Анхааруулга: Savings хийх боломжтой хамгийн бага хэмжээг сайн хараарай. Мөн хугацаа дуусахаас өмнө savings үйлчилгээг цуцласан тохиолдолд өгөөж бодогдохгүй болохыг анхаарна уу.




ДИЖИТАЛ ЭКСЧЕЙНЖ МОНГОЛИА

Н.ТУСЛАМЖ ЦЭС АШИГЛАХ


Н.ТУСЛАМЖ ЦЭС АШИГЛАХ

1. ТҮГЭЭМЭЛ АСУУЛТУУД

▶ **АЛХАМ 1.** Тусламж товчийг дараад Түгээмэл асуултууд цэсийг сонгоно.




▶ **АЛХАМ 2.** Түгээмэл асуулт хариултууд гарч ирэх бөгөөд өөрт хэрэгтэй хэсгийг сонгож асуултандаа хариугаа аваарай.




2. Хэрэглэгчийн хүсэлт илгээх


▶ **АЛХАМ 1.** Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр **нэвтэрч** орно.



▶ **АЛХАМ 2.** Тусламж товчийг дараад **Хүсэлт** илгээх цэсийг сонгоно.



▶ **АЛХАМ 3.** Шинээр хүсэлт илгээх товчин дээр дарна.



▶ **АЛХАМ 4.** Шаардлагатай мэдээллийг оруулаад, хүсэлтээ илгээнэ.

1. **Таны холбогдож буй ерөнхий шалтгаан** хэсгээс шалтгаанаа сонгоно.
2. **Хүсэлтийн төрөл сонгох** хэсгээс төрлөө сонгоно
3. **Хүсэлтийн гарчиг** хэсэгт тухайн бичих гэж байгаа асуудалтайгаа холбоотой гарчиггаа бичиж үлдээнэ.
4. **Тайлбар** хэсэгт өөрт гарсан асуудлаа товч тодорхой бичиж үлдээнэ.
5. Хэрэв файл нэмэх шаардлагатай байгаа бол **Файл хуулах** товчин дээр дарж өөрийн төхөөрөмж дээрээс файлаа сонгон нэмж оруулна.
6. **I'm not a robot** хэсгийг зөвлөж Илгээх гэсэн товчин дээр дарж хүсэлтээ илгээнэ.
7. **Илгээх** товчин дээр дарж хүсэлтийг илгээнэ.

Хүсэлт илгээх

Тусламж > Хүсэлт илгээх

● **Анхааруулга**

○ Хүсэлтийг хүлээн авсан тухай мэдэгдэл болон хүсэлтийн хариуг таны бүртгэлтэй имэйл рүү илгээнэ. Хүсэлтээ дэлгэрэнгүй тодорхойлж илгээвэл шийдвэрлэх хугацаа хурдан байна.

ТАНЫ ХОЛБОГДОЖ БУЙ ЕРӨНХИЙ ШАЛТГААН

1

ХҮСЭЛТИЙН ТӨРӨЛ СОНГОХ

2

ХҮСЭЛТИЙН ГАРЧИГ

3

ТАЙЛБАР

4

ФАЙЛ 1 - ФАЙЛ НЭМЭХ

5

ФАЙЛ 2 - ФАЙЛ НЭМЭХ

ФАЙЛ 3 - ФАЙЛ НЭМЭХ

6 I'm not a robot

reCAPTCHA
Privacy - Terms


7




Анхааруулга: Таны илгээсэн хүсэлтийг 24 цагийн дотор хүлээн авч хариу өгөх болно.

3. Утасны апп татах

▶ **АЛХАМ 1.** Тусламж товчийг дараад **Утасны апп татах** цэсийг сонгоно.



▶ **АЛХАМ 2.** Таныг App store/Play store хуудсанд авчрах бөгөөд **Get/Download** товчин дээр дарж татна.






ДИЖИТАЛ ЭКСЧЕЙНЖ МОНГОЛИА

I.ТОХИРГОО


I.ТОХИРГОО

1. НЭВТРЭХ НУУЦ ҮГЭЭ СОЛИХ


▶ **АЛХАМ 1.** Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр **нэвтэрч** орно.



▶ **АЛХАМ 2.** Профайл зурган дээр дараад **Тохиргоо** цэсийг сонгоно.




▶ **АЛХАМ 3.** Нэвтрэх нууц үг хэсэг дээрх **Солих** товчин дээр дарна.



▶ **АЛХАМ 4.** Одоо ашиглаж буй нууц үг болон шинэ нууц үгээ оруулж нууц үгээ шинэчилнэ.

1. **Одоо ашиглаж буй нууц үг** хэсэгт ашиглаж байгаа нууц үгээ хийнэ.
2. **Шинэ нууц үг** хэсэгт нууц үгээ шинээр зохиож хийнэ.
3. **Шинэ нууц үгээ баталгаажуулна уу** хэсэгт шинээр зохиосон нууц үгээ давтан хийнэ.
4. **Хадгалах** товчин дээр дарна.



Анхааруулга: Таны зохиож буй нууц үг хамгийн багадаа 6 оронтой 1 том үсэг, 1 жижиг үсэг, 1 тоо, 1 тусгай тэмдэгт орсон байх ёстой.

2. ГАР УТАСНЫ ДУГААРАА СОЛИХ

Таны манай системд бүртгүүлж баталгаажуулсан мэдээлэл өөрчлөгдсөн бол аюулгүй байдлын үүднээс та өөрөө солих боломжгүй байдаг. Тиймээс та дугаар солих хүсэлтээ support@trade.mn имэйл рүү эсвэл Хэрэглэгчийн хүсэлт-ээр ямар шалтгаанаар, бүртгэлтэй дугаараа ямар дугаараар солих хүсэлтэй байгаа талаар хүсэлтээ бичиж илгээх шаардлагатай.

Хүсэлтдээ дараах мэдээллийг хавсарган илгээх шаардлагатай.

- » Бүртгэлтэй дугаар болон солих гэж байгаа шинэ дугаар
- » Иргэний үнэмлэхний нүүр, ар талын зураг
- » Иргэний үнэмлэхээ бариад хажууд нь цаасан дээр Trade.mn, тухайн өдрийн огноо, гарын үсгээ бичээд хамт барьсан селфи зураг



Анхааруулга: Таны илгээсэн хүсэлтийг манай харилцагчийн үйлчилгээний ажилчид өдөр бүр хүлээн авч, 24 цагийн дотор танд хариу өгөх болно.

3. ИМЭЙЛ ХАЯГ СОЛИХ

Таны манай системд бүртгүүлж баталгаажуулсан мэдээлэл өөрчлөгдсөн бол аюулгүй байдлын үүднээс та өөрөө солих боломжгүй байдаг. Тиймээс та солих гэж буй шинэ имэйл хаягнаасаа имэйл солих хүсэлтээ support@trade.mn имэйл рүү ямар шалтгаанаар, бүртгэлтэй имэйлээ ямар имэйлээр солих хүсэлтэй байгаа талаар хүсэлтээ бичиж илгээх шаардлагатай.

Хүсэлтдээ дараах мэдээллийг хавсарган илгээх шаардлагатай.

- » Бүртгэлтэй имэйл болон солих гэж байгаа шинэ имэйл
- » Иргэний үнэмлэхний нүүр, ар талын зураг
- » Иргэний үнэмлэхээ бариад хажууд нь цаасан дээр Trade.mn, тухайн өдрийн огноо, гарын үсгээ бичээд хамт барьсан селфи зураг




Анхааруулга: Таны илгээсэн хүсэлтийг манай хүлээн авч, 24 цагийн дотор танд хариу өгөх болно.


4. ШИНЭЭР ХАЯГ ХАДГАЛАХ

Хадгалсан хаягууд хэсэгт та байнга крипто зарлага хийдэг хаягаа хадгалах боломжтой бөгөөд хадгалсан хаягруугаа зарлага гаргаж болно.


▶ **АЛХАМ 1.** Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр **нэвтэрч** орно.



▶ **АЛХАМ 2.** Профайл зурган дээр дараад **Тохиргоо** цэсийг сонгоно.




▶ АЛХАМ 3. Хадгалсан хаягууд хэсэг дээрх **Солих** товчин дээр дарна.




▶ АЛХАМ 4.

1. **Хадгалах нэр** хэсэгт тухайн хадгалах хаягтаа дурын нэрийг өгч хадгалах боломжтой.
2. **Валют** хэсэгт хадгалах гэж байгаа крипто валютын төрлийг сонгоно.
3. **Хаяг** хэсэгт зарлага хүлээн авагч талын крипто валютын орлогын хаягийг хуулж тавина.
4. **Сүлжээ** хэсэгт крипто валютын сүлжээг сонгоно.
5. **Хүлээн авагчийн хаягийн төрөл** хэсэгт **Бирж хаяг/Хэтэвч хаяг** сонголтуудаас хүлээн авагч талын хаягийн төрлөөс хамааран сонгоно.
6. **Хаяг нэмэх** товчин дээр дарна.



Анхааруулга: Хадгалж байгаа хаягаа давхар шалгах хэрэгтэй ба таны хөрөнгө алдагдахаас сэргийлэн сүлжээгээ дахин нягтлан шалгах хэрэгтэй.

▶ **АЛХАМ 5.** Хадгалсан хаягаа устгах бол хаягийн хажууд байрлах **ХОГИЙН САВАН** дээр дарна.



▶ **АЛХАМ 6.** Та устгахдаа итгэлтэй байгаа бол **Тийм** товчин дээр дарна.

